

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН БАРГИЛТ ТӨМРИЙН ОРДЫГ АШИГЛАХ
ТӨСЛИЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-016657

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 2550466

ХЯНАСАН:

БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын
мэргэжилтэн

_____ П.ШИНЭЦЭЦЭГ

ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАСАН:

"Монголросцветмет" ТӨҮГ-ын харьяа Бор-Өндөр УБҮ-ийн захирал -2

_____ Б.МАГСАРЖАВ



БОЛОВСРУУЛСАН:

"Монголросцветмет" ТӨҮГ-ын харьяа Бор-Өндөр УБҮ-ийн Байгаль орчин, нөхөн
сэргээлт хариуцсан ахлах мэргэжилтэн

_____ Б.Мөнххүлэг

2022 ОН

АГУУЛГА

ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	3
1.1 Төсөл хэрэгжүүлэгч.....	3
1.2 Хүчин чадал	3
1.3 Төслийн зорилго.....	3
1.4 Ордын байршил, нөөц	4
1.5 Түүхий эд, байгалийн баялгийн ашиглалт, эрчим хүч, ус, дулааны хэрэгцээ	4
1.5.1 Түүхий эд, байгалийн баялгийн ашиглалт	4
1.5.2 Эрчим хүч, ус, дулааны хэрэглээ	5
1.6 Техник, технологийн сонголт	5
1.6.1 Олборлолтын технологи.....	5
1.6.2 Олборлолтонд ашиглах тоног төхөөрөмж, түүний сонголт.....	7
1.6.3 Баяжуулалтын технологи	7
1.7 Эцсийн болон завсрын бүтээгдэхүүн, хог хаягдал болон түүнийг эргүүлэн ашиглах, зайлуулах арга зам.....	11
1.7.1 Эцсийн болон завсрын бүтээгдэхүүн	11
1.7.2 Хог хаягдал болон түүнийг эргүүлэн ашиглах, зайлуулах арга зам	12
2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	16
I. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	17
II. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	19
III. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	19
IV. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	19
V. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20
VI. Химийн бодисын осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	20
VII. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	Error! Bookmark not defined.
VIII. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	22
IX. БОМТ-ний хэрэгжилтийг олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө	Error! Bookmark not defined.
X. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	23
Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр.....	25
3. ДҮГНЭЛТ.....	28



Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн байршлын тойм зураг	5
Зураг 2. Хүдэр баяжуулах технологийн схем	8
Зураг 3. Нойтон соронзон баяжмалын түүхий эд тээвэрлэх маршрут	11
Зураг 4. Орчны хяналт шинжилгээ хийх цэгийн байршил.....	25

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Хүчин чадал	4
Хүснэгт 2. Усны нийт хэрэглээ.....	5
Хүснэгт 3. Ил уурхайн ашиглалтын технологийн схем	6
Хүснэгт 4. Олборлолтын тоног төхөөрөмж	7
Хүснэгт 5. Хуурайн соронзон 1-р шугамын баяжуулалтын тоног төхөөрөмжийн үзүүлэлт, насжилт	9
Хүснэгт 6. Хуурайн соронзон 2-р шугамын баяжуулалтын тоног төхөөрөмжийн үзүүлэлт, насжилт	10
Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө.....	16
Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	18
Хүснэгт 9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	20
Хүснэгт 10. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	22
Хүснэгт 11. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	23
Хүснэгт 12. Хяналт шинжилгээний цэгийн байршлын солбилцол	25
Хүснэгт 13. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн хуваарь.....	26
Хүснэгт 14. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах.....	28



ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Төсөл хэрэгжүүлэгч

“Монголросцветмет” ТӨҮГ-ын харьяа “Бор-Өндөр УБҮ”

1.2 Хүчин чадал

Тус ордын нөөцийг уурхайг нээснээс хойш 9-10 жилийн хугацаанд олборлохоор төлөвлөсөн байна. Уурхай нь бүтэн жилийн турш ажлын 7 өдөр, хоногт 2 ээлжээр тасралтгүй горимоор ажилладаг. Ээлжийн ажлын цагийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

Уурхайн хүрээн дэх үйлдвэрлэлийн 19856 мян.тонн нөөцийг 9-10 жил ашиглахаар төлөвлөсөн. 2010 оны 11 сарын 1-нээс уурхайн бэлтгэл ажлыг эхлүүлсэн.

Тус орд газарт 2011 оноос эхлэн олборлолт явуулсан бөгөөд энэ хугацаанд 4,075.229 тн хүдэр олборлож, 11,823.000 м³ хөрс хуулсан байна. Хүдрийн талбайн хүрээнд орших нөөцийн хэмжээ 15291.9 мян.тн болох бөгөөд түүнийг 7 жилийн хугацаанд олборлоно.

Хүснэгт 1. Хүчин чадал


№	Технологийн үе шат	Хүчин чадал, мян.тн		
		хоног	сар	жил
1	Олборлолтын хүчин чадал	7.05	211.5	2400.0
2	Хуурай баяжуулалт	5.0	150.6	1700.0
3	Нойтон баяжуулалт	1.46	43.6	500.0

1.3 Төслийн зорилго

Уулын баяжуулах “Бор-Өндөр” үйлдвэрийн байгуулагдсанаас хойшхи 30 жилийн хугацаанд (1982-2012 онууд) хайлуур жоншны ордуудын ашиглалтын ажиллагаа эрчимтэй явагдсаны улмаас түүний хайлуур жоншны эрдэс, түүхий эдийн бааз ихээхэн хэмжээгээр буураад байна. Дэлхийн зах зээл дээрх хайлуур жоншны металлурги ба флотацын баяжмалын үнэ огцом унаснаар үйл ажиллагаанд өөр төрлийн ашигт малтмал, тодорхойлбол төмрийн хүдрийг татан оруулах шаардлага гараад байна. “Монголросцветмет” ТӨҮГ нь ашигт малтмалын ашиглалтын MV-016657 дугаартай төмрийн хүдрийн Баргилт ордын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг. Ордын хүдрийн балансын нөөц нь В+С ангиллаар 34.84% төмрийн агуулгатай 18 сая.тн төмрийн хүдрийн нөөцтэй. “Монголросцветмет” ТӨҮГ нь 2010 онд ШУТИС-ийн Уул уурхайн хүрээлэнгийн боловсруулсан ТЭЗҮ-ийн дагуу Баргилт төмрийн хүдрийн орд газрын ил аргаар олборлох ашиглалтын үйл ажиллагааг 2011 оноос эхлүүлэн явуулж байна.

1.4 Ордын байршил, нөөц

Баргилт Овоо төмрийн хүдрийн орд нь засаг захиргааны хувьд Хэнтий аймгийн Дархан сумын нутагт байрладаг. Улаанбаатар хотоос зүүн урагш 320км, Дархан сумаас баруун урагш 35 км, Бор-Өндөр сумаас баруун хойш 12 км тус тус зайтай байна.



Зураг 1. Төслийн байршлын тойм зураг

Хүдрийн талбайн хүрээнд орших нөөцийн хэмжээ В+С нөөцийн ангиллаар 2016 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар үйлдвэрлэлийн нөөц 16174.84 мян.тн байсан бол 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар 15272.048 мян.тн болсон байна.

1.5 Түүхий эд, байгалийн баялгийн ашиглалт, эрчим хүч, ус, дулааны хэрэгцээ

1.5.1 Түүхий эд, байгалийн баялгийн ашиглалт

Тус төслийн гол зорилго нь газрын доорх байгалийн нөөц баялаг болох ашигт малтмал ашиглах явдал юм. Үндсэн түүхий эд нь байгалийн баялаг байна. Хүдрийн талбайн хүрээнд орших нөөцийн хэмжээ В+С нөөцийн ангиллаар 2016 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар үйлдвэрлэлийн нөөц - 16174.84 мян.тн байсан бол 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар 15272.048 мян.тн болсон байна.



1.5.2 Эрчим хүч, ус, дулааны хэрэглээ

Эрчим хүч

Уурхайн үндсэн хэрэглээ 6 кВ, үүнээс гадна баяжуулах үйлдвэр, засварын цех, аж ахуйн байрууд, ТМ түр хадгалах агуулах, ШТС болон бусад туслах чанарын объектууд 0.4 кВ-ын цахилгаан эрчим хүч хэрэглэнэ. Эдгээр хэрэглэгчидийн ЦЭХ-ний эх үүсвэрээр нь төвийн эрчим хүчний системийн БЗӨБЦТС ТӨХК-ийн Говьсүмбэр салбарын 110/35/6 кВ-ийн “Бор-Өндөр” дэд станцаар тэжээгдэнэ.

Усны хэрэглээ

Ус хэрэглээний эх үүсвэр нь зам талбайн тоосжилт дарах, өрөмдлөгийн ус, унд ахуйн ус хэрэглээ болон биологийн нөхөн сэргээлтийн усны хэрэглээ зэрэг байна.

Хүснэгт 2. Усны нийт хэрэглээ

№	Ус хэрэглээний эх үүсвэр	Ус хэрэглээний хэмжээ, м ³			
		л/с	1 хоног	1 сар	1 жил
1	Өрөмдлөгийн ус хэрэглээ	1.91	100.5	2816.5	33798.0
2	Зам талбайн тоосжилт бууруулах	0.81	38.8	1088	13056.0
2	Биологийн нөхөн сэргээлт	0.57	69.3	1941	23302.0
3	Унд ахуй	0.35	33.2	924.5	11096.0
	Нийт	3.64	241.8	6770	81252

Замын тоосжилт дарах, унд ахуйн болон биологийн нөхөн сэргээлтийн усны хэрэглээг 1.5 л/с ундарга бүхий 2 гүний худгаас хангана. Өрөмдлөгийн усны хэрэглээг шүүрлийн усаар хангана. ТЭЗҮ-д шүүрлийн усны тооцоог залгаа орших “Монголпросцветмет” ТӨҮГ-ын уурхайн 1470 м түвшингийн ашиглалтын явцын гидрогеологийн нөхцөлөөр ундаргыг 172.8 м³/хоног гэж тооцоолсон байна.

1.6 Техник, технологийн сонголт

1.6.1 Олборлолтын технологи

Баргилтын ордын үйлдвэрлэлийн зэргээр нөөц бодогдсон 1, 2-р хүдрийн биетүүдийг нэг ил уурхай үүсгэн ашиглана. Хүдрийн биетийн байршлийн нөхцөл, хүдрийн талбайн рельеф зэргээс хамаарч уулын ажил 1525 м-ийн доошхи түвшинд явагдана. Хөрс хуулалтын хязгаарын коэффициент, уурхайн хил хязгаар энэхүү нэмэлтээр өөрчлөгдөж байгаатай холбогдуулан хөрс хуулалтын коэффициент болон бусад уулын ажлын параметрууд дор дурдсанаар өөрчлөлтүүд орж байгаа болно.



Хүснэгт 3. Ил уурхайн ашиглалтын технологийн схем

Ашиглалтын технологи	Ил уурхайн үндсэн ажил	Технологийн процесс
Авто тээвэртэй ашиглалтын технологи	Хөрс хуулалт	Өрөмдлөг тэсэлгээ
		Ухаж ачих
		Тээвэрлэх
		Овоолох
	Хүдэр олборлолт	Өрөмдлөг тэсэлгээ
		Ухаж ачих
		Тээвэрлэх
		Овоолох

Орд нь эгц босоо ($\beta \approx 60^\circ$) уналтай тул ашиглалтын түвшин бүрт хөрс хуулалт ба олборлолтын ажил (хучаас хөрснөөс доошхи хэсэгт) явагдана.



1.6.2 Олборлолтонд ашиглах тоног төхөөрөмж, түүний сонголт

Олборлолтонд ашиглах техник, тоног төхөөрөмжийг дараах хүснэгтэд үзүүлэв.


Хүснэгт 4. Олборлолтын тоног төхөөрөмж

№	Үзүүлэлт	Ашиглаж буй техник		
		Марк	Тоо	Төлөв
1	Экскаватор	ЭКГ-5А	2	Хэвийн
		ZAXIS 870H	1	Хэвийн
		Hyundai 500	1	Хэвийн
		CAT 374F L	1	Хэвийн
		Liebherr R924B	1	Хэвийн
		Liebherr R966	1	Хэвийн
2	Өрмийн машин	СБШ-250	3	Хэвийн
		СБУ-100	2	Хэвийн
		JK730№1, 300SCYN№1	1	Хэвийн
3	Бульдозер	CAT9DR	1	Хэвийн
		Liebherr L776	1	Хэвийн
		TY165-3	1	Хэвийн
		D65E-12	1	Хэвийн
4	Авто ачигч	SEM676	1	Хэвийн
		SEM653	1	Хэвийн
		SEM656	1	Хэвийн

1.6.3 Баяжуулалтын технологи

Баргилтын төмрийн хүдрийг соронзон аргаар ангилах туршилт болон хүдрийн минералоги болон ширхэглэлийн шинжилгээний дүн зэргийг үндэслэн тухайн ордын хүдрийг хуурай болон нойтон соронзонгийн ялгалтаар баяжуулж болохыг тогтоосон.

Баргилтын орд дээр жилдээ нийтдээ 1700 мян.тн төмрийн хүдэр боловсруулж 52%-аас багагүй төмрийн агуулгатай төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэхээр төлөвлөхдөө түүнийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Эхний ээлжид жилдээ 600 мян.тн төмрийн хүдэр боловсруулах модуль хуурай соронзон баяжуулах шугам, 2 дугаар ээлжид жилдээ 1100 мян.тн хүдэр баяжуулах шугамыг байгуулахаар тооцсон. Төмрийн хүдрийг хуурай соронзон аргаар баяжуулах эхний шугамыг 2014 онд барьж байгуулан ашиглалтад оруулсан бөгөөд удаах шугамыг зах зээлийн эрэлт хэрэгцээ, нөхцөлтэй уялдуулан 2018 онд ашиглалтад оруулсан.



Зураг 2. Хүдэр баяжуулах технологийн схем

Хуурай соронзон баяжуулалт

- Хүдэр бэлтгэх ажиллагаа

Хуурай соронзон баяжуулалтын 3 шатлалтад бутлагдсан бүтээгдэхүүний оновчтой хэмжээ 10 мм-ээс бага байх шаардлагатай тул сонгосон алхан бутлуурын ажиллагаа зөвхөн урьдчилсан шигшилттэйгээр энэхүү нөхцөлийг хангах боломжтой. Иймд хуурай соронзон баяжуулалтад орох төмрийн хүдрийн боловсруулалтын 3-р шатны бутлалтын өмнө урьдчилсан шигшилтийг $-50+10$; $-10+0$ мм буюу 2 фракциар ангилалт хийнэ.



- *Үндсэн баяжуулалт*

Бутлуураас гарсан 10 мм хүдрийг үндсэн хуурхай соронзон сепаратороор баяжуулна. Хуурай соронзон баяжуулах байгууламжуудыг барьж байгуулснаар 52%-аас багагүй төмрийн агуулгатай төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэхээс гадна дараагийн нойтон баяжуулалтад орохуйц завсрын бүтээгдэхүүнийг гаргах нөхцөл бүрдэнэ.

Хүснэгт 5. Хуурайн соронзон 1-р шугамын баяжуулалтын тоног төхөөрөмжийн үзүүлэлт, насжилт

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Тоо, хэмжээ ш	Ашиглалтанд орсон он	Ашигласан жил	Цаашид ашиглах	Техникийн үзүүлэлт
1	Колосник шигшүүр		1	2014	3	7	Торны хэмжээ 600*600 мм
2	Хүлээн авах бункер		1	2014	3	7	Эзлэхүүн 31м ³ , Металл
3	Чичиргээт тэжээгч	GZD 1100x4900	1	2014	3	7	1100x4900 мм
4	Хацарт бутлуур	PE900x1200	1	2014	3	7	Оролтын амны хэмжээ 900x1200 мм
5	Туузан дамжуулагч №1		1	2014	3	7	В-1000мм, L-20 п.м.
6	Конусан бутлуур	CS160B	1	2014	3	7	Q=132-253 т/цаг, гаралтын амны хэмжээ 16-38мм, цах. хөдөлгүүрийн чадал 160 кВт, жин 27 тн
7	Туузан дамжуулагч №3		1	2014	3	7	L-25 п.м, В-500мм
8	Дамарт сепаратор	CS3200	1	2014	3	7	В-1000мм. Напряженность магн.поля/ Соронзон хүчлэг 3200
9	Туузан дамжуулагч №2		1	2014	3	7	В-1000мм, L-20 п.м.
10	Туузан дамжуулагч №4		1	2014	3	7	В-800мм, L-20 п.м.
11	Туузан дамжуулагч №7		1	2014	3	7	В-800мм, L-15 п.м.
12	Инерцийн шигшүүр	YK2160	1	2014	3	7	6300x2300 мм
13	Конусан бутлуур	CS160D	1	2014	3	7	Q=27-90 т/цаг, разгрузочная щель /гаралтын амны хэмжээ 3-13мм, цах. хөдөлгүүрийн чадал 75 кВт, жин 15 тн
14	Конусан бутлуур	CS75D	1	2014	3	7	Q=36-163 т/цаг, разгрузочная щель /гаралтын амны хэмжээ 3-16мм, цах. хөдөлгүүрийн чадал 160 кВт, жин 27 тн



15	Туузан дамжуулагч №6		1	2014	3	7	В-800мм, L-10 п.м.
16	Туузан дамжуулагч №5		1	2014	3	7	В-800мм, L-25 п.м.
17	Туузан дамжуулагч №8		1	2014	3	7	В-650мм, L-11 п.м.
18	Туузан дамжуулагч №9		1	2014	3	7	В-650мм, L-11 п.м.
19	Бутлагдсан хүдрийн бункер		1	2014	3	7	V=м³
20	Чичиргээт тэжээгч	GZD650x2300	2	2014	3	7	
21	Чичиргээт дозатор		3	2014	3	7	
22	Соронзон ангилагч барабан	STC7524	2	2014	3	7	Соронзон орны хүчлэг - энгийн
23	Туузан дамжуулагч №15		1	2014	3	7	В-500мм, L-25 п.м.
24	Туузан дамжуулагч №12		1	2014	3	7	В-500мм, L-12 п.м.
25	Туузан дамжуулагч №11		1	2014	3	7	В-500мм, L-10 п.м.
26	Соронзон ангилагч барабан	STC7524	1	2014	3	7	Соронзон орны хүчлэг – өндөр
27	Туузан дамжуулагч №10		1	2014	3	7	В-500мм, L-10 п.м.
28	Туузан дамжуулагч		1	2014	3	7	В-500мм, L-25 п.м.
29	Туузан дамжуулагч №14		1	2014	3	7	В-500мм, L-25 п.м.

Хүснэгт 6. Хуурайн соронзон 2-р шугамын баяжуулалтын тоног төхөөрөмжийн үзүүлэлт, насжилт

№	Тоног төхөөрөмжийн нэр болон марк	Хэмжээ, ш	Ашиглалтанд орсон он	Ашигласан жил	Цаашид ашиглах жил	Техникийн товч тодорхойлолт
1	Хүлээн авах бункер	2	2017	0	10	V=40м³, бункерийн ачааллах хэсэг-өргөн 3,1м, урт 4,2м, Металл
2	Чичиргээт тэжээгч GZD 900*3600	2	2017	0	10	Q=100-160 т/цаг, тэжээгчид орох хүдрийн хамгийн том хэмжээ 600мм, хэмжээ В*L- 900*3600мм, хөдөлгүүрийн чадал 7,5 кВт
3	Хацарт бутлуур PE 600*900	2	2017	0	10	Q=100-160 т/цаг, хүлээн авах амны хэмжээ 600*900мм, гаргах амны хэмжээ 65-160мм, цах.хөдөлгүүрийн чадал 75 кВт
4	Туузан дамжуулагч №1(1а)	2	2017	0	10	Туузны өргөн 1000 мм, конвейерын урт 25 м.
5	Хацарт бутлуур PE 250*1200	4	2017	0	10	Q=50-80 т/цаг, хүлээн авах амны хэмжээ 250*1200мм, гаргах амны хэмжээ 20-50мм, цах.хөдөлгүүрийн чадал 45 кВт, орох хүдрийн хамгийн том хэмжээ 65-160мм.
6	Туузан дамжуулагч №2(2а)	2	2017	0	10	Туузны өргөн 1000 мм, конвейерын урт 25 м, туузны урт 58м.



7	Шкив-н соронзон сепаратор	2	2017	0	10	Диаметр 600 мм, урт 900мм. Соронзон орны хүчдэл 4000GS
8	Туузан дамжуулагч №3	1	2017	0	10	Туузны өргөн 800 мм, конвейерын урт 25 м
9	Чичиргээт шигшүүр	2	2017	0	10	В- 1500мм, L-4000мм
10	Алхан бутлуур PC 2000	2	2017	0	10	Q=115-180 т/цаг, тэжээх бүхэллэг хүдрийн хамгийн том хэмжээ – 100мм-ээс бага, буталсны дараах хүдрийн хэмжээ - ≤ 25мм, цах.хөдөлгүүрийн чадал 220 кВт
11	Туузан дамжуулагч №4(4а)	2	2017	0	10	Туузны өргөн 1000 мм, конвейерын урт 22 м
12	Дамаран соронзон сепаратор CTG1030	2	2017	0	10	Q=150-180 т/цаг, дамар: урт 3000мм, диаметр 1050мм, цах.хөдөлгүүрийн чадал 15 кВт, орох хэмжээ 0-10мм.
13	Туузан дамжуулагч №5	1	2017	0	10	Туузны өргөн 1000 мм, конвейерын урт 15 м
14	Туузан дамжуулагч №6	1	2017	0	10	Туузны өргөн 1000 мм, конвейерын урт 15 м
15	Туузан дамжуулагч №7		2017	0	10	Туузны өргөн 1000 мм, конвейерын урт 19 м
16	Туузан дамжуулагч №8		2017	0	10	Туузны өргөн 1000 мм, конвейерын урт 21 м
17	Туузан дамжуулагч №9		2017	0	10	Туузны өргөн 800 мм, конвейерын урт 19 м
18	Шкив-н соронзон сепаратор	1	2017	0	10	Диаметр 600мм, урт 900мм, Соронзон орны хүчдэл 4000GS
19	Дамаран соронзон сепаратор CTG1024	1	2017	0	10	Q=130-180 т/цаг, дамар: урт 2400мм, диаметр 1050мм, цах.хөдөлгүүрийн чадал 5,5 кВт, орох хэмжээ 0-10мм.
20	Туузан дамжуулагч №10	1	2017	0	10	Туузны өргөн 600 мм, конвейерын урт 22 м
21	Туузан дамжуулагч №11	1	2017	0	10	Туузны өргөн 800 мм, конвейерын урт 21 м

2013 онд “Бор-Өндөр” уулын баяжуулах үйлдвэрийн хайлуур жонш баяжуулах үйлдвэрийг түшиглэн Баргилтын төмрийн хүдрийг боловсруулах зорилготой баяжуулах фабрикийн өөрчлөлтийн төсөл боловсруулж, түүний дагуу УБҮ-ийн БФ-ийн холбогдох нэмэлт шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэсэн. Үүний дагуу Баяжуулах фабрик дээр шинээр соронзон ангилалтын шугам суурилуулж, өмнө ашиглагдаж байгаа хүдэр бэлтгэх, усгүйжүүлэх, савлах хэсгийг ашиглахаар зохицуулалт хийсэн юм. Нойтон баяжуулалтын фабрик нь Баргилтын төмрийн хүдрийн орд газраас 18 км зайд байрлана.

1.7 Эцсийн болон завсрын бүтээгдэхүүн, хог хаягдал болон түүнийг эргүүлэн ашиглах, зайлуулах арга зам

1.7.1 Эцсийн болон завсрын бүтээгдэхүүн

Баргилтын ордын төмрийн хүдрийг хуурай соронзон баяжуулалтын 2 шугамаар баяжуулна. 1-р шугамаар 52%-ийн төмрийн агуулгатай 240.0 мян.тн/жил хүдэр, 35.74%-ийн төмрийн агуулгатай 150.0 мян.тн/жил завсрын бүтээгдэхүүн

гарна. 2-р шугамаар 52%-ийн төмрийн агуулгатай 440.0 мян.тн/жил хүдэр, 35.29%-ийн төмрийн агуулгатай 275.0 мян.тн/жил завсрын бүтээгдэхүүн гарна. Завсрын бүтээгдэхүүнийг уурхайгаас 18 км зайд орших Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн нойтон баяжуулалтын фабрикт баяжуулна. “Бор-Өндөр” үйлдвэрийн баяжуулах фабрик дээр боловсруулж, баяжуулахад 65.3% агуулгатай баяжмалын гарц нь 49.8%, Металл авалт-93.4%, хаягдлын гарц нь төмрийн 4.57% агуулгатай хаягдал 50.2% байхаар байна.



Зураг 3. Нойтон соронзон баяжмалын түүхий эд тээвэрлэх маршрут

1.7.2 Хог хаягдал болон түүнийг эргүүлэн ашиглах, зайлуулах арга зам

Хатуу, шингэн хог хаягдал нь хүн ам, үйлдвэрлэлд хэрэгцээт газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэнд аажмаар орох ба задрах хугацаа нь удаан байдаг учраас байгаль орчинд хор хөнөөлтэй.

Хог хаягдлыг энгийн, ахуйн, аюултай гэх мэтээр Монгол улсын Хог хаягдлын тухай хуульд заасан бөгөөд эдгээрийг хэлбэрээр нь хатуу, шингэн, хийн гэж ангилав.

- Энгийн хог хаягдал гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг хэлнэ.
- Ахуйн хог хаягдал гэж айл өрхөөс гарах энгийн хог хаягдлыг хэлнэ.

1. Аюултай хог хаягдал



Аюултай хог хаягдал гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг хэлнэ.

Хатуу хог хаягдал

Баяжуулалтын хаягдал, хөрсний овоолго, шатах тослох материалаар бохирдсон хөрс, засварын цехээс гарах сэлбэг хэрэгсэлийн хаягдал зэрэг аюултай шинжтэй хатуу хог хаягдал гарна.

Баяжуулалтын хаягдал: Баяжуулалтын хаягдлын хэмжээ 595 мян.тн/жил байна. Хүдэр нь хортой хольц агуулаагүй, баяжуулах явцад химийн бодис ашиглахгүй учир баяжуулалтын хаягдал нь хоруу чанар багатай юм. Гэхдээ аливаа бохирдуулагч бодис дам байдлаар үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлж байнгын хяналт шинжилгээг БОМТ-д заасан зөвлөмж, хуваарийн дагуу хийж гүйцэтгэх шаардлагатай.

Хөрсний хаягдал: Хөрсний хаягдлын хэмжээ 1660-3700 мян.м³ байна. Шинжилгээний үзүүлэлтээс харахад хөрсөн дэх Хром (Cr)-ын хэмжээ 8.36-12.9 мг/кг, Хар тугалга (Pb) 30.3-39.1-68.2 мг/кг, Кадми (Cd)-илрээгүй, Никель (Ni)-11.4-52.4 мг/кг, Цайр (Zn) 9.51-16,9 мг/кг, Зэс (Cu)-22.7-70.3 мг/кг тус тус агуулагдсан нь хөрсөнд агуулагдах зохих хэмжээнд байгаа ба “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008 стандарт”-ийн хүлцэх агууламжийн үзүүлэлтээс доогуур хэмжээнд байна. Хөрс, хурдсыг техноген үйлчлэлээр үйлчлэхэд хоруун чанар нь нэмэгддэг. Ийм учраас аливаа бохирдуулагч бодис дам байдлаар үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлж байнгын хяналт шинжилгээг БОМТ-д заасан зөвлөмж, хуваарийн дагуу хийж гүйцэтгэх шаардлагатай.

Шатах тослох материалаар бохирдсон хөрс: Засварын талбай орчим болон шатах тослох материалын агуулахын орчим шатах тослох материалаар бохирдсон хөрс алаг цоог тархсан байна.

Шатах тослох материалаар бохирдсон хөрсийг хуулж тусгайлан бэлтгэсэн талбайд саармагжуулж байх шаардлагатай (сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмжийн хэсгээс үзнэ үү).

Техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хаягдал: Засварын цехээс янз бүрийн овор хэмжээтэй төмөр, металл эд анги, жижиг хэрэгсэл, эрэг боолт, хуванцар хэсэг, аккумулятор, шатах тослох материалын сав, бөглөө, жийргэвч резин, ашиглахгүй болсон агаар шүүгч гэх мэт сольсон эд ангийн хаягдал гарна. “Монголпросцветмет” ТӨҮГ-ын мэдээллээр 1 жилд дунджаар 188 ширхэг дугуйны хаягдал, 40 ширхэг аккумулятор гардаг. Хаягдал дугуйг баяжуулах фабрикийн хаягдлын сангийн хаягдал дамжуулах шугам хоолойн холболт, бусад зүйлд дахин ашиглахаар хаягдлын аж ахуйд хуримтлуулж байна. Аккумуляторын дахин сэргээн



ашиглах боломжгүй хэсгийг “Хаягдал өнгөт металл” худалдан авагч иргэн, аж ахуй нэгжид нийлүүлж байна. “Бор-Өндөр” УБУ нь 2018 онд 63 ширхэг хаягдал аккумуляторын гэрээ байгуулж 1338000 төгрөгөөр үнэлэн худалдсан.

Шингэн хог хаягдал

Баяжуулалтанд ус ашиглахгүй учир технологийн процессоос хаягдал гарахгүй. Аюултай шинжтэй гол шингэн хаягдал нь шатах тослох материалын хаягдал юм. Тос, тосолгооны материалын жилийн хэрэглээ 56459 кг юм. Тээврийн хэрэгсэлийн тос, тосолгооны материалыг засварын цехэд солих нөхцөлд жил бүр энэ хэмжээний тос, тосолгооны хаягдал гарах боломжтой төсөл хэрэгжүүлэгчийн мэдээллээр жилд дунджаар 4402 тн ашигласан масло, тос гардаг. Тус хаягдлыг УБУ-ийн нефьт баазад байрлах аюултай хог хаягдал хадгалах зориулалтын байгууламжид эргүүлэн татаж аюултай хог хаягдал нийлүүлэх тусгай эрх бүхий аж ахуй нэгжид нийлүүлж байна. Мөн уурхай болон бусад механизм, тоног төхөөрөмжийн тосолгоонд дахин ашиглаж байна.

Хийн хог хаягдал

Автомашины утааны найрлагад нийтдээ 200 гаруй төрлийн хорт бодис, химийн нэгдэл оролцдог. Зарцуулагдах түлшний жингийн 15% нь ашигтай зарцуулагдаж, үлдсэн 85% нь агаарт цацагддаг байна.

Тус уурхайн үйл ажиллагаанаас элэгдэл, эвдрэлд орсон газар болон хуурай аргын баяжуулах үйлдвэр зэрэг нь тоосжилтын эх үүсвэр болно.

Талбайн эх үүсвэр буюу элэгдэл, эвдрэлд орсон гадаргаас нэгж хугацаанд ялгарах тоосонцорын хэмжээг доорхи томъёогоор тодорхойлов. Хүдрийн овоолго, барилга, байгууламж зэргээс тоосжилт үүсэхгүй. Нэгж ялгаралтын хэмжээ нь 0.13 кг/с бөгөөд элэгдэл, эвдрэлд орсон хөрсний гадарга дээрээс тоос, тоосонцор босох хурдны үед энэ төрлийн ялгаралт ажиглагдана. Туршилтын үр дүнгээр 5 м/с буюу түүнээс дээш хурдны үед тоос, тоосонцор агаарт дэгдэнэ. Цаг уурын станцын мэдээнээс үзэхэд 5 м/с буюу түүнээс дээш хурдтай салхины давтагдлын тоо 70 бол элэгдэл, эвдрэлд орсон хөрсөн бүрхэвчээс 786.24 тн/жил хийн хаягдал ялгарна.



2. Энгийн хог хаягдал

Ахуйн шинжтэй хатуу хог хаягдал

Тус уурхайгаас гарах ахуйн гаралтай хатуу хог хаягдлын эх үүсвэр нь ажилчдын хэрэглээ, хоол бэлтгэлийн явц байх болно. Хатуу хог хаягдлын дийлэнхи хувийг сав баглаа боодол эзэлнэ. Уурхайн үйл ажиллагаанаас доорхи нэр төрлийн хатуу хог хаягдал гарахаар байна. Үүнд:

- Хүнсний зүйлсийн сав, баглаа боодол
- Бие засах газрын хаягдал
- Ундааны сав, лааз
- Хоолны үлдэгдэл
- Бусад

Тус уурхайд тогтмол 205 хүн ажиллахаар төсөлд тусгагдсан бөгөөд бүрэн хүчин чадлаараа ажилласан нөхцөлд дараах хэмжээний хатуу хог хаягдал гарахаар байна. Нэг хүн хоногт ойролцоогоор 0.3 кг хаягдал гаргана гэж тооцоход 1 хоногт 0.3 кг/хүн* 205 хүн = 61.5 кг, 1 сард 1845 кг, 1 улиралд 5.5 тн, 1 жилд 22.4 тн ахуйн гаралтай хатуу хаягдал гарахаар байна.

Ахуйн хог хаягдлыг Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын “БОР-ӨНДӨР ХОТ ТОХИЖИЛТ ОНТҮГ-тай 2020-2021 онд “Хог хаягдал ачиж тээвэрлэх тухай” ВУ-2020-02-10 тоот гэрээ байгуулан сумын хог хаягдлын цэгт ачиж зайлуулдаг.

Шингэн хог хаягдал

Унд ахуйн усны хэрэглээнээс шингэн хаягдал гарна. Энэхүү шингэн хаягдлын хэмжээ нь ус хэрэглээний 80% гэж үзвэл 1 хоногт 24.6 м³, 1 сард 738 м³, 1 жилд 8856 м³ ахуйн шингэн хаягдал гарна. Шингэн хаягдлыг бохир хуримтлуулах цооногт хуримтлуулан Бор-Өндөрийн цэвэрлэх байгууламжинд зөөврөөр нийлүүлдэг.



2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжүүлэгч: “Монголпросцветмет” ТӨҮГ-ын харъяа Бор-Өндөр УБҮ

Хамрах хугацаа: 2022 он

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нарийвчилсан үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаварыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү төлөвлөгөөгөөр төмрийн хүдэр олборлох, баяжуулах үйл ажиллагаатай холбогдон бий болох болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөв. Мөн энэхүү БОМТ нь Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй нягт уялдах бөгөөд төслийн хэрэгжилтийн хугацааны туршид болон уурхай хаагдсаны дараах өөрчлөлтийн хяналт шинжилгээ, гадаргын болон газар доорхи ус, хөрсний чанар, ургамал, амьтны аймагт гарч байгаа өөрчлөлтүүдийг тухай бүрт нь шинжилж, холбогдох арга хэмжээг жил бүрийн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байх шаардлагатай.

БОМТ-ний биелэлтийг тухайн жилийн хяналт, үзлэгээр төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, холбогдох хяналтын байцаагч нар, төсөл хэрэгжүүлэгч нарт иргэдээс тавьсан шаардлага, хүсэлтийг хэрхэн биелүүлсныг ч бас авч үзэж байх ёстой.

БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 12 сарын 10-ний дотор БОАЖЯаманд ирүүлэх бөгөөд, жилд 1 удаа орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчид, сонирхогч талуудад төслийн талаар танилцуулж хэлэлцүүлэг зохион байгуулсан.



2.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Баргилт MV-016657 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайд хамаарах, Төрийн захиргааны төв байгууллагаар батлуулсан, Байгаль орчны менежментийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт					
Д/д	Үзүүлэлт	Төлөвлөсөн ажил	Гүйцэтгэл	Зардал /сая.төг/	
1.	I. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Агаар			
		Уурхайн дотоод замыг услах, хөрс барьцалдуулагч шингэнээр шүрших (Cutoff8, CaCl8, MgICI,-н хольц, FLOSET SR71 г.м)	Замыг тогтоосон хувиарын дагуу замын усалгааг хийж гүйцэтгэн ажилласан.	Үйлдвэрлэлийн зардалд	
		Уурхайн зам арчилгааг тогтмолжуулж шаардлагатай газар сайжруулалт хийх	Тээвэрлэлтийн үндсэн нэг зам болон уурхайн талбайн замуудад хийгдэх арчилгааг тогтмолжуулж шаардлагатай газар сайжруулалт хийж ажилласан.	Үйлдвэрлэлийн зардалд	
		Гадаргын ба газрын доорх усны нөөц			
		Хөрсөн дээр нефтийн бүтээгдэхүүн асгаж гоожуулахгүй, асгарсан тохиолдолд шингээх, саармагжуулах арга хэмжээ авах	Хөрсөн дээр нефтийн бүтээгдэхүүн асгаж гоожуулахгүй байх зааварчилгааг ажилчдад тогтмол өгдөг. Мөн хөрсөн дээр асгарсан тохиолдолд шингээх, саармагжуулах ажлыг зохион байгуулж давтан зааварчилгааг өгч сургалтанд хамруулдаг.	Үйлдвэрлэлийн зардалд	
		Хүнд машин механизм, тээврийн хэрэгслэлийн хөдөлгөөнөөр зам харгуйн дагуу ус тогтох боломжтой хонхор хотгор газруудыг хусах, боломжгүй нөхцөлд дүүргэлт хийн тэгшлэх,	Зам харгуйн дагуу ус тогтох боломжтой газруудыг хусаж, боломжгүй нөхцөлд үйлдвэрлэлийн хаягдал дайрга дэвсэн тэгшилсэн.	Үйлдвэрлэлийн зардалд	
		Газрын доорх усны органик ба геохимийн бохирдолтыг хянах, уст цэгүүдээс усны хими бактериологийн шинжилгээний үр дүнд эрүүл ахуйн дүгнэлт өгч байх,	Хэнтий аймгийн УЦУОШТ-тэй гэрээ байгуулан жилд 2 удаа хяналт, шинжилгээ хийлгэсэн бөгөөд . /Гэрээ, шинжилгээний дүнг хавсаргав/ Мөн УБУ нь Эрүүл ахуйч мэргэжилтэнтэй болсон	БОМТ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардалд	



Хөрсөн бүрхэвч		
Олон салаа зам гаргахгүй байх, үйлдвэр рүү очих, баяжмал тээвэрлэх замын маршрутыг тодорхой тогтоож тэмдэгжүүлэх, тэмдэг тэмдэглэгээг сайжруулж засварлах	Олон салаа зам гаргахгүй байх талаар цехийн удирдлага болон холбогдох ИТА, жолооч нарт зааварчилгаа болон зөвлөмж хүргүүлсэн. Уурхайн дотоод болон Бор-Өндөр УБУ-рүү хүдэр тээвэрлэхэд замын дагуу тэмдэг тэмдэглэгээг байршуулсан, замын арчилгааг тогтмолжуулсан.	Үйлдвэрлэлийн зардалд
Шимт хөрсний нөөц бий болгох	2021 онд 60 га газар Дархан сумын ИТХ-аар шийдвэрлүүлэн авч хөрсний овоолгыг байршуулсан. Мөн хуучин шимт хөрсний овоолгыг сэргээж олон наст ургамал тарих ажлыг эхлүүлээд байна.	
Газрын хэвлий		
Бүтээгдэхүүн тээвэрлэх машинуудын даац хэтрүүлэхгүй байх	Бүтээгдэхүүн тээвэрлэж буй машинууд Автопүүгээр жин тонноо тооцуулдаг. Тогтоосон норм хэмжээний дагуу тээвэрлэлт хийдэг.	
Маршрутын бус замаар бүтээгдэхүүн тээвэрлэхгүй байх, шаардлагагүй замуудыг хаах	Маршрутын дагуух замаар тээвэрлэлт хийгдэж байна.	
Ажиллагсдын тосгоноос гарах хатуу, шингэн, хог хаягдлыг зориулалтын тусгай цэгт, эмх цэгцтэй хадгалах, зохих цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх	Ахуйн хог хаягдлыг төвлөрсөн цэгт түр хадгалан “БОР-ӨНДӨР ХОТ ТОХИЖИЛТ” ОНТҮГ-тай гэрээ байгуулан хуваарийн дагуу ачиж зайлуулсан. Сар бүр уурхайн орчны нийтийн их цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийсэн.	Үйлдвэрлэлийн зардалд
Ургамлан нөмрөг		



		Үйлдвэрлэл, уурхайн зам, талбайн ашиглалтад хяналт тавьж, хэвийн ашиглалттай байхад анхаарч, тухай бүр нь арчилж тордох,	Үйлдвэрлэл болон зам талбайн ашиглалтад хяналт тавьж, шаардлагатай хэсгүүдэд сайжруулалт хийн ажиллаж байна.	Үйлдвэрлэлийн зардалд	
		Ургамлын зүйл өөрчлөгдөх, биомассын хэмжээ бууралтын байдалд хяналт шинжилгээ хийлгэж байх,	Хэнтий аймгийн УЦУОШТ-тэй гэрээ байгуулан жилд 2 удаа хяналт, шинжилгээ хийлгэдэг бөгөөд уурхайн үйл ажиллагаанаас хамаарч ургамлын зүйл төрөл цөөрөөгүй гэсэн дүгнэлт гарсан. Мөн нөлөөллийн бүсэд байгаа малчин өрхүүдтэй уулзаж санал хүсэлтийг авч ажиллаж байна. / Гэрээ, шинжилгээний дүнг хавсаргав /	Үйлдвэрлэлийн зардалд	
		Амьтны аймаг			
		Зэрлэг амьтдын амьдардаг гол тархац нутаг уст цэг орчимд өвс, тэжээл, хужир шүү тавьж өгөх, өвөл хаврын хуурайшилт ихтэй үед усан хангамжийг сайжруулах зэргээр биотехнологийн арга хэмжээ авах	Зэрлэг амьтадын амьдардаг гол тархац бүхий хэсэгт хужир шүү зэргийг байршуулж өгсөн. / Зураг хавсаргав /.	Үйлдвэрлэлийн зардалд	
2.	II. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Төлөвлөөгүй.	-	-	
3.	III. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Бор-Өндөр УБУ-ийн MV-016657 тусгай зөвшөөрөлтэй талбайн гадна			
		Бор-Өндөр УБУ-ийн <u>MV-016657</u> тусгай зөвшөөрөлтэй талбайн гадна, Дархан сумын ЗДТГ-ын ногоон байгууламжид 5000 ширхэг модны суулгац тарьж ургуулах	Хэнтий аймгийн Дархан сумын ЗДТГ-ын хүсэлтээр 5000н модны суулгацыг акт үйлдэн хүлээлгэн өгсөн. / актыг хавсаргав /	27,500,000	
4.	IV. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	Тухайн жилд холбогдох асуудлаар ямар нэгэн зөрчил болон өргөдөл гомдол гарсан тохиолдолд хууль, журмын дагуу шийдвэрлэнэ..	Энэхүү асуудлаар ямар нэгэн өргөдөл, гомдол гараагүй.	-	



5.	V. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Нүүдлийн соёл иргэншлийг судлах болон олон улсын хүрээлэнгийн гүйцэтгэсэн археологийн авран хамгаалах судалгаагаар түүх, археологийн дурсгал илрээгүй байна.	Түүх, соёлын өвийн дурсгалт зүйл илрээгүй.	1,000,000-
6.	VI. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	Байгаль орчин, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа		Үйл ажиллагааны зардалд
Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулах,		Бүх ажилчдад гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулсан.		
Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах		Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай хэсгүүдэд байрлуулсан. / Зургаар хавсаргав /		
Автомашинуудыг кабиныг битүүмжлэл сайтай болгох		Автомашинуудын кабиныг битүүмжлэл сайтай болгож өгсөн.		
Аянга, цахилгаантай ширүүн бороотой үед гадаах ажлыг түр зогсоох		- Аянга, цахилгаантай ширүүн бороотой үед гадаах ажлыг түр зогсоож ажилласан.		
Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах		Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулж ажилласан.		
Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг ажилчдын байр бүрт байрлуулах		- Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг ажилчдын байр бүрт байрлуулсан.		
Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах		- Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулсан. -		
Машины кабин бүрт эмийн сан, галын хор байрлуулах		Машины кабин бүрт эмийн сан, галын хор байрлуулан үзлэгийг тогтмолжуулсан.		
- Галын аюулаас сэргийлэх				
Цахилгаан тоног хэрэгслийн газардуулга бүрэн бүтэн байх		- Газардуулга бүрэн бүтэн байгаа бөгөөд байнгын шалгалт үзлэг хийж байгаа.		



		- Үйлдвэрийн технологи хэрэглээ, унд ахуй, галаас хамгаалах усны нэгдмэл, болон зөөврийн усны шугамаар тоноглогдсон байх	- УБУ-нь Аврах албатай бөгөөд шаардлагатай машин, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон.	
		- Болзошгүй гал түймрийн үед ашиглах техник хэрэгсэл, багаж төхөөрөмжтэй байх, тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг ажиллагаанд хяналт тавьж байх	- Гал унтраах багаж хэрэгслээр бүрэн хангагдсан.	
		Ахуйн		
		-		
		- Үйлдвэрийн ахуйн хатуу хог хаягдалд хоол хүнс, түлш, угаалга цэвэрлэгээний материалын сав, баглаа боодол болох мод, цаасан хайрцаг, хуванцар болон шил сав, гялгар уут зэрэг материалуудыг цуглуулаад хуванцар, шил, төмөр ба бусад төрлөөр нь хуваан ангилж, цааш ашиглах боломжгүй хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэг рүү зөвшөөрөлтэй ААН-ээр зайлуулах.	- “БОР-ӨНДӨР ХОТ ТОХИЖИЛТ ОНТҮГ-тай гэрээ байгуулан хог хаягдлын цэг рүү ачиж зайлуулж байна. /Гэрээг хавсаргав/	
		- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж түр хадгалах хогийн бункер байрлуулах /хаягдал төмөр ашиглах/	- Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай 2 ангилан ялгах хогийн савыг ажилчдын цайны газрын хэсэгт байршуулсан.	
		Уурхайн ажилчдад өөрсдийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдал, түүнийг хэрхэн ангилан ялгах, боломжтойг дахин ашиглах талаар сургалт явуулах,	- Хаягдал резин дугуйн тоо хэмжээг гарган ангилж, БФ-ийн Хаягдлын аж ахуйн өвлийн бэлтгэл ажилд ашигласан. Мөн УБУ-ийн ажилчдын авто зогсоолд ашигласан.	
		- Автомашины сэлбэг, төмрийн хаягдлыг УБУ-т тушаах тусгай эрх бүхий аж ахуй нэгжид нийлүүлэх	- Автомашины сэлбэг, төмрийн хаягдлыг жин тонныг нь тодорхойлон УЦ-ийн Барилгын хэсэгт хүлээлгэн өгсөн	
		- Гал тогооноос гарсан хоол, хүнсний хаягдлыг бордоо болгох	- Гал тогооноос гарсан хоол, хүнсний хаягдлыг бордоо болгох, хувийн аж ахуй эрхэлдэг иргэдэд өгсөн.	
		-		
		Аюултай		
		-		
7	VII. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө			2,6



		<p>- Аюултай хог хаягдал тээвэрлэх, хадгалах, устгах үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан нийлүүлэх, Түр хадгалах тохиолдолд зориулалт бүхий байгууламжид хадгалах.</p> <p>-</p>	<p>Аюултай хог хаягдал тээвэрлэх, хадгалах, устгах үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулсан ажилладаг, түр хадгалах тохиолдолд зориулалтын газарт хадгалж байна.</p>	
8.	VIII .Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	<p>- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хуваарийн дагуу тухайн жилд шинжилгээг 2 удаа гүйцэтгүүлэх</p>	<p>- Хяналт шинжилгээний 1 дэх удаагийн дээжлэлтийг Хэнтий аймгийн УЦУОШТ болон “Монголросцветмет” ТӨҮГ-ын харьяа Бор-Өндөр УБУ-ийн хооронд байгуулсан 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн ВU-2022-03-13 тоот “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу гүйцэтгүүлэн дүн шинжилгээг гаргуулсан. /Гэрээ болон шинжилгээний дүнг хавсаргав./</p> <p>Хяналт шинжилгээний 2 дэх удаагийн дээжлэлтийг Хэнтий аймгийн УЦУОШТ болон “Монголросцветмет” ТӨҮГ-ын харьяа Бор-Өндөр УБУ-ийн хооронд байгуулсан 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн ВU-2022-03-22 тоот “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу гүйцэтгүүлэн дүн шинжилгээг гаргуулсан. /Гэрээг хавсаргав.</p>	3.0
9.	IX. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	<p>Уурхайн бүх ажиллагсдын дунд байгаль хамгааллын сургалтуудыг технологи ажиллагааны онцлогоос хамааруулан зохион байгуулах, дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд хийгдэж буй мод тарих ажилд нийт цех хэсгүүдийн ажилчдыг хамруулах анхан шатны мэдлэг олгох</p> <p>-</p>	<p>- Уурхайн нийт ажиллагсдын дунд ХАБЭА-н хэлтэс, Сургалтын инженертэй хамтран Байгаль орныг хамгаалах талаар мэдлэг олгох зорилгоор сургалт зохион байгуулсан. Биологийн дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд цех хэсгүүдийн нийт ажиллагсдад мод тарих, усалгаа, арчилж ургуулах талаар анхан шатны сургалтыг явуулсан, цахим орчинд уриалга, мэдээллүүдийг байршуулж ажилласан.</p>	Үйл ажиллагааны зардалд




		<p>- Ажлын байрны хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилчдыг илчлэг, витаминлаг хоол хүнсээр хангах</p>	<p>- Ажлын байрны хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилчдыг кемпийн хоолны газрын илчлэг, витаминлаг хоол хүнсээр хангаж ажилласан. Мөн дархлаа дэмжих витамин нэмэлт бүтээгдэхүүнийг ажилтан бүрд улирал болгон олгож байна.</p>	
		<p>- Уурхайн хүнсний хэрэглээний мах, махан бүтээгдэхүүнийг 2-р багаас хангаж байх</p>	<p>Уурхайн хүнсний хэрэглээний мах, махан бүтээгдэхүүнийг Хэнтий аймгийн Дархан болон Бор-Өндөр сумаас хангаж байна.</p>	
		<p>- Уурхайн хүнсний хэрэглээний мах, махан бүтээгдэхүүнийг 2-р багаас хангаж байх</p>	<p>Уурхайн хүнсний хэрэглээний мах, махан бүтээгдэхүүнийг Хэнтий аймгийн Дархан болон Бор-Өндөр сумаас хангаж байна.</p>	
		<p>- Өвөлжилт болон цаг үе хүндэрсэн үед малын өвс тэжээл тээвэрлэхэд шаардлагатай техникийн туслалцаа үзүүлэх</p>	<p>- Санал хүсэлт ирүүлээгүй.</p>	
		<p>Уурхайд ажиллаж байгаа ажиллагсадын тухайн ажлыг хийж гүйцэтгэх мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор мэргэжлийн сургалтанд хамруулж байх</p>	<p>Уурхайд ажиллаж байгаа нийт ажиллагсадд ХАБЭА-н хэлтэсээс ажил гүйцэтгэх мэдлэг болон чадвар сайжруулах зорилгоор сургалтанд хамруулсан.</p>	
10.	<p>Х. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөлөлийн бүсийн оршин суугчдад тайлагнах хуваарь</p>	<p>Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах хуваарь</p>	<p>- 2022 оны III-р улирал Хэнтий аймгийн Дархан сумын ЗДТГ-ын дарга болон ИТХ-н төлөөлөгчид иргэдтэй уулзалт хийж байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг танилцуулсан. Мөн Ivp улиралд Дархан сумын багийн хуралд оролцож иргэдийн санал хүсэлттэй танилцсан.</p>	



Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ.



Зураг 44. Орчны хяналт шинжилгээ хийх цэгийн байршил

Хүснэгт 127. Хяналт шинжилгээний цэгийн байршлын солбилцол

№	Хяналтын цэг	Өргөрөг	Уртраг
1	агаар-1	46° 19' 43.943" N	109° 16' 52.036" E
2	агаар-2	46° 19' 37.946" N	109° 16' 58.411" E
3	агаар-3	46° 20' 12.367" N	109° 17' 18.082" E
4	агаар-4	46° 19' 28.321" N	109° 17' 19.237" E
5	агаар-5	46° 20' 8.592" N	109° 15' 46.904" E
6	агаар-6	46° 19' 54.472" N	109° 17' 6.120" E
7	хөрс, ургамал-1	46° 19' 31.761" N	109° 17' 38.121" E
8	хөрс, ургамал-2	46° 20' 3.371" N	109° 16' 40.793" E
9	хөрс, ургамал-3	46° 19' 17.728" N	109° 17' 15.019" E
10	ус-1	46° 20' 1.773" N	109° 16' 52.610" E
11	ус-2	46° 19' 35.407" N	109° 16' 48.973" E
12	ус-3	46° 19' 48.184" N	109° 16' 28.651" E



Хүснэгт 83. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн хуваарь

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, сая.төг	Нийт зардал, сая.төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Агаарын чанар	Тоосонцор: TSP, PM2.5, PM10	Тоос хэмжигч зөөврийн багаж худалдан авч тогтмол хэмжилт хийх	-	-	MNS 4585:2016 MNS 6063:2010 MNS 5002:2000 MNS 3113:1981 MNS 5885:2008 Агаарын тухай хууль Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
	SOx NOx COx цацраг болон бусад	Жилд 2-с доошгүй удаа	0.08	0.5	
	Дуу чимээ чичиргээ, доргио	Жилд 2-с доошгүй удаа. 1 удаа хэмжихдээ 24 цагийн турш	-	-	
	Нийт зардал			0.5	
Хөрсөн бүрхэвч	Механик бүрэлдэхүүн Хими, физикийн шинж чанар Бохирдол Хүнд металл /Pb, Cd, Hg, As, Cr,.../ Нефтийн бүтээгдэхүүн Бактереологи	Жилд 2 удаа	0.065	0.5	MNS 5850 : 2008 MNS 3298 : 1991 MNS 5546 : 2005 MNS 3985 – 87 MNS 2305 - 94
	Нийт зардал			0.5	
Ус	Хүнд металл Анион, катион Бактереологи Худаг, цооногуудын усны түвшин, түүний өөрчлөлт	Жилд 2 удаа	0.2	0.5	MNS 3934:1986 MNS /ISO/ 5667-11:2000 MNS / ISO / 5667-11:2000 MNS 6148:2010 MNS 5667:10:2001 MNS 6148:2010 MNS /ISO/ 5667-11:2000 MNS 3934:1986 MNS /ISO/ 5667-11:2000 MNS 4943:2011 MNS 900:2005 Усны тухай хууль
	Нийт зардал			0.5	



“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ХАРЪЯА БОР-ӨНДӨР УБУ

Ургамлан нөмрөг	Ургамлын гарц, ургамал бүрхэвч Ургац Өндөр Биомасс Нягт Төрөл зүйл Бүлгэмдэл Ховор, эмийн, ашигт чанар	Жилд 2 удаа	0.75	0.5	Ургамлын тухай хууль MNS 6191:2010 MNS 3474 : 2003
	Нийт зардал			0.5	
Хяналт шинжилгээний томилолт, унааны зардал				1.0	
Нийт				3,0	

3. ДҮГНЭЛТ

“Монгоросцветмет” ТӨҮГ-ын харъяа Бор-Өндөр УБҮ нь Хэнтий аймгийн Дархан сумын нутагт “Баргилтын төмрийн хүдрийн ордыг ашиглах” төслийг хэрэгжүүлж байна.

Байгаль орчны менежментийн 2022 оны төлөвлөгөөний биелэлтийг Монгол улсын Байгаль хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланг үндэслэн боловсруулав.

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тус төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, хяналт шинжилгээ хийх зорилго бүхий нийт 10 төрлийн 42 арга хэмжээг хэрэгжүүлсэн. Шууд зардалд нийт 34,1 сая төгрөг зарцуулсан, бусад зардал үйлдвэрлэлийн үйл ажиллагааний зардалд багтсан болно.



**УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УЛМААС ЭВДЭРСЭН
ГАЗРЫН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН
МЭДЭЭ**

1. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХАЯГИЙН ХЭСЭГ

Регистрийн дугаар	2	5	5	0	4	6	6
Аж ахуйн нэгж байгууллагын нэр	“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ						
Байршил	Нэр			Код			
Аймаг, нийслэл	Хэнтий						
Сум, дүүрэг	Дархан						

2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Тусгай зөвшөөрлийн дугаар	М	V	0	1	6	6	5	7
Тусгай зөвшөөрлийн талбай, га	133.08							
Ашиглалт эхэлсэн он, сар, өдөр	2011.09.02							
Ашигт малтмалын төрөл	Төмрийн хүдэр							
Ашиглалтын төрөл	Ил уурхайн аргаар, өрөмдлөг тэсэлгээний ажлаар нурааж, олборлох							

3. УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТ

Үзүүлэлт	МД	Хэмжих нэгж	Нийт	Тайлант онд /ашиглалт/
А	Б	В	1	2
Олборлолтод өртсөн нийт талбай	1	га	5.4	5.4
Ашигласан талбай	2	га	13.9	13.9
	3	мян.м ³	54,161	5,416
Хаягдал чулуулгийн овоолго	4	га	0.02	0.01
	5	мян.м ³	168	6.8
Хөрсний овоолго	6	га	0,7	0,3
	7	мян.м ³	1,456	353
Уул уурхайн дагалдах дэд бүтцийн нөлөөнд эвдэрсэн газар	8	га		
Бусад	9	га		



4. УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

Үзүүлэлт	МД	Хэмжих нэгж	Нийт	Техник	Биологи
А	Б	В	1	2	3
Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээнд заасан нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ	1	га			
	2	мян.м ³			
Тайлант онд нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн талбай	3	га		Төлөвлөөгүй	Төлөвлөөгүй
	4	мян.м ³			
Нөхөн сэргээлтийн нийт хийсэн талбай	5	га		Төлөвлөөгүй	Төлөвлөөгүй
	6	мян.м ³			
Тайлант онд нөхөн сэргээлт хийсэн талбай	7	га		Төлөвлөөгүй	Төлөвлөөгүй
	8	мян.м ³			
Нөхөн сэргээлт хийхэд нийт зарцуулсан зардал	9	Мян.төг			
Тайлант онд нөхөн сэргээлт хийхэд зарцуулсан зардал	10	Мян.төг			
Байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгө	11	Сая.төг		37,776	
Тайлант онд байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгө	12	Сая.төг		17,08	
Байгаль хамгаалахад зарцуулсан нийт зардал	13	Мян.төг			
Тайлант онд байгаль хамгаалахад зарцуулсан зардал	14	Сая.төг		45,77	

Тайлан гаргасан:

Инженер

Маркшейдер

Хүлээн авсан:

УУА-ны мэргэжилтэн